

Living the Lotus

4
2022

VOL. 199

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Бурханд мөргөхийн утга учир

Шагжамүни будда алс хол газраас сүслэн мөргөхөөр зорин ирсэн шавь нар, сүсэгтэн олныг угтан авахдаа “Замд чинь саад бэрхшээл тохиолдоогүй биз дээ? Хоол хүнсээр дутагдаж гачигдав уу? Хамт явсан нөхөд чинь бүгд сайн уу?” гэж заавал асуудаг байжээ.

Нэгэн удаа хэсэг шавь нараасаа урьдын адилаар “Бүгдээрээ сайн явж ирэв үү?” гэж асуутал нэг шавь нь “Нэг нөхөр маань хүнд өвчин туссан боловч танд мөргөх сэтгэлээ орхиж үл чадан үлдээгээд ирлээ” гэж хариулжээ. Шагжамүни будда “Надтай уулзахаас илүүтэй өвдсөн нөхрөө асарч үлдсэн бол мянган бээрийн цаана байсан ч надтай уулзсанаас ялгаагүй билээ” хэмээн сургамжилсан гэдэг.

Миний дүрийг харах гэж ирэх бус үзэл санааг минь чанд баримталж, өөрийн болгож чадах хүн л миний жинхэнэ шавь гэдгийг ийнхүү захин сургажээ.

Бурханд мөргөн залбирна гэдэг нь бурханлаг сэтгэлтэй болохын төлөө залбирах явдал юм. Өвдөж шаналж буй нэгнээ асарч тойлон, тусалж дэмжих нь Буддагийн үзэл санаа билээ. Тиймээс бид зовж шаналж буй нэгнээ авран нигүүлсэх үйлийг урьтал болговол зохилтой.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X222-223

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 199 (2022.04)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Талархах сэтгэлийн илэрхийлэл “Шагшаабад”

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Шагшаабадын үндэс нь талархах сэтгэл

Бид төрсөн цагаасаа авахуулаад маш олон зүйлийн ачаар амьдардаг гэж би үргэлж хэлдэг. Тэгвэл өдөр бүр бусдын ач буянд талархаж амьдардаг уу гэвэл өөртөө итгэлтэйгээр “тийм” гэж хэлэх хүн ховор байх. Цаг агаарт бухимдан гомдоллож, гэр бүлийнхэндээ хүртэл “баярлалаа” гэсэн ганцхан үгийг хэлж чаддаггүй хүн ч байгаа болов уу.

Зургаан барамидын сургаалд бодисадва хүний хэрэгжүүлэх нэг үйл бол “шагшаабад” хэмээн сургасан байдаг. Ханзны утга нь “сахин баримтлах” ба “зөв дадал зуршлыг суулгах” гэсэн утгатай Sila гэдэг санскрит үгнээс гаралтай ажээ. Шагшаабадыг “сахил” ч гэж хэлдэг тул тэгж болохгүй, ингэж болохгүй гэсэн барьж хориглосон сургаал гэсэн ойлголт байдаг. Гэхдээ угтаа шагшаабад нь бүгдээрээ хамтдаа аз жаргалтай болохыг зорьдог бодисадвагийн үйлд яг л таарсан өөдрөг гэгээлэг сургаал юм.

Энэ сургаал нь маш олон зүйлийн ачаар амьдардаг гэсэн бурханы сургаалын үндсэн ухагдахуунтай нягт холбоотой. Биднийг тэтгэн амьдруулж буй бүх зүйлд талархах сэтгэлээр бүх нийтийн аз жаргал, сайн сайхны төлөө үйл хийх нь Бурханы хүсэл бөгөөд бодисадва хүний зорилго билээ. Тэгвэл тэр талархсан сэтгэлийнхээ илэрхийлэл болгон бидний хийж чадах зүйл бол эргэн тойрныхоо хүмүүсийн сэтгэлийг амирлуулах юм. Хаана ч ямар ч газар байгаль дэлхийн хуулийн дагуу бүх зүйл харилцан биенээ нөхөж, эв найрамдалтай байх зохилдлогоотой байдаг. Тиймээс эргэн тойрныхоо хүмүүсийг амар амгалан, сайхан амьдруулах зөв дадлыг өөртөө суулгаж, түүнийгээ хэрэгжүүлэх чухал. Энэ нь өөрийг тэтгэн амьдруулж буй хамаг юмс бүхэнд талархах сэтгэлээ илэрхийлэх “шагшаабад” хэмээх бодисадвагийн үйл билээ.

Эгэл сүсэгтэн хүний таван сахил гэж байдаг. Үүнд амьтны амь хөнөөх, хулгай хийх, эр эмийн буруу харилцаа, худал хэлэх, архи дарс уухыг тэвчих ордог. Эдгээрийг аваад үзсэн ч бүгд эргэн тойрондоо төвөг удахгүй, бусдын сэтгэлийг

сэвтээн гомдоохгүй байхыг анхааруулсан байдаг. Бүх амь насыг хүндэтгэж, үнэ цэнийг нь гаргаж, гэр бүл найз нөхөд, танилуудтайгаа эвтэй найртай сайхан амьдрах нь өөрт ч гэсэн хамгийн их аз жаргал биш гэж үү.

Өөрийнхөө шагшаабадын үйлийг тодорхойлох

Робот судлалын нэрт эрдэмтэн, буддизмын талаар гүнзгий мэдлэгтэй Мори Масахиро гуай “Хүн бүр өөр царайтай байдаг шиг хүн хүний зуршил, сул тал ч гэсэн өөр өөр байдаг. Тэгэхээр баримтлах сахил нь ч гэсэн өөр өөр байж таарна” гэж хэлжээ. Өөрөөр хэлбэл зөвхөн өөртөө тохирсон “зөв дадал зуршил буюу шагшаабад”-ыг сонгон хэрэгжүүлэх чухал гэсэн үг юм.

Тэгвэл одоо таван сахилаас гадна өөртөө хэвшүүлэх шаардлагатай дадлын талаар бодож үзэцгээе. Жишээлбэл байнга хоцроод бусдад төвөг удчихаад байдаг хүнд “болзсон цагаасаа 5, 10 минутын өмнө очих хэрэгтэй” гэж өөртөө байнга хэлдэг байсан Үүсгэн байгуулагчийн дадал хэрэг болж магадгүй. Харин өөрийн мэдэлгүй дүрсхийн уурлачихаад байдаг хүн уурлах гээд ирэхээрээ “Ум инээгээрэй инээгээрэй, уурлахгүй шүү” гэсэн тарнийг уншин гүнзгий амьсгаа авах дадлыг өөртөө суулгах юм бол эргэн тойрондоо эвгүй уур амьсгал бий болгохгүй байхад хэрэг болно гэж бодож байна.

Хүн бүрийн хэрэгжүүлбэл зохих шагшаабад ийнхүү харилцан адилгүй байх ба үүнийг ямар өнцгөөр харахаас шалтгаалаад өдөр тутмын амьдралын дүрэм ч гэж хэлж болох байх. Гэхдээ дүрэм журмаас ялгаатай нь хэрэгжүүлж буй хүн нь олон зүйлийн ачаар амьд яваадаа талархан, бүгдээрээ хамтдаа аз жаргалтай, эв найртай байх гэсэн хүсэл зорилго тээн хэрэгжүүлдэг явдал юм. Мөн эргэн тойрондоо эв найрамдлыг түгээх бусдын төлөө гэсэн энэ үйлээр дамжуулж тухайн хүн өөрөө ч баяр хөөрийг мэдэрдэг. Энэ утгаараа шагшаабад нь өөрийн болоод өрөөл бусдын сайн сайхны төлөөх бодисадвагийн үйлд ордог.

Цас их ордог улсад “Хавар модны үндэснээс эхэлдэг” гэж ярьцгаадаг. Яагаад гэвэл модны үндэс дэх цас бусад газраас түрүүнд хайлж эхэлдэг болохоор тэр. Үүсгэн байгуулагчийн төрсөн нутаг Сүганүма тосгоны хаврыг эргэн санахуйд нил цасан дунд Чинжү удган модны үндэсний цас хайлан тойрог үүсгэсэн байдаг ба сакүра цэцэг нь гялтганан дэлбээлж эхлэх урин үе санаанд орно.

Хүмүүс бид ч гэсэн бурхан тэнгэрийн ач ивээлд талархан, байгаль дэлхийн зохилдлогооны дагуу амьдрах дадлыг өөртөө суулгаж, урин хавар мэт амар амгалан өдрүүдийг өнгөрүүлбэл сайхансан.

“Косей” сэтгүүл, 4-р сарын дугаар

Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)

Үүсгэн байгуулагчийн намтар ба Рисшо Косей Кай нийгэмлэгийн түүх

Үүсгэн байгуулагч таалал төгссөн нь

Рисшо Косей Кай нийгэмлэгийн Үүсгэн байгуулагч, дэлхийн энх тайвны төлөө бүхий л амьдралаа зориулсан тэрээр 1999 оны 10 сарын 4-нд 92 насандаа таалал төгссөн юм.

Оршуулах ёслолд нийгэмлэгийн гишүүдээс гадна шашин, улс төр, бизнесийн салбарын 60,000 гаруй хүн ирж Үүсгэн байгуулагчийн алдар гавьяаг магтан, бурханы оронд амгалан нойрсохыг ерөөсөн.

Нивано ерөнхийлөгч “Буяны магтуу” дээр өөрийн аав, багш болох Үүсгэн байгуулагчийн талаар самсаа шархирам дурсамжийг ярьж, гүн талархал илэрхийлэн, цаашид бурханы үйлд улам илүү шамдахаа тангарагласан.



● Бяцхан мэдлэг

10 сарын 10-ны өдөр болсон Үүсгэн байгуулагчийг эцсийн замд нь үдэх ёслол дээр Эшин Ватанабэ, Тэндай урсгалын тэргүүн Шинтаро Ишихара, Гэгээлэг нийгмийг байгуулах үндэсний хөдөлгөөний зөвлөлийн дарга Сэйичи Шираянаги, Дэлхийн шашны энх тайвны чуулгын японы хороон дарга зэрэг хүмүүс ирж эмгэнэл илэрхийлжээ.

Нивано Ничикоо ерөнхийлөгч



Нивано ерөнхийлөгч нийгэмлэгийн гишүүдийн аз жаргал, дэлхийн амар амгалангийн төлөө өдөр хоногийг маш завгүй өнгөрөөдөг.

Их ариун ордоны ёслолоор гишүүдэд сургаал айлдаж, улсын хэмжээнд “Сургаал түгээх аян” хийн сүм хийдүүдээр айлчилж, номын өргөөний бурхан залах ёслолд оролцоно.

Мөн бусад шашны байгууллагуудаар айлчлан энх тайвны талаар ярилцаж, НУБ-ын хурлыг даргалах, дэлхийн шашны чуулганд оролцох зэргээр энх тайвныг тогтоох үйлсэд идэвхтэй хичээн зүтгэж байна.


Тэрээр сайхан сэтгэл, сургаал номыг хичээнгүйлэн суралцдаг дүр төрхөөрөө гишүүдийн хүндлэлийг хүлээдэг билээ.



Бяцхан мэдлэг

Нивано ерөнхийлөгч дэлхийн шашны энх тайвны чуулгын Япон дахь төвийн удирдах зөвлөлийн дарга, тус байгууллагын олон улсын хорооны дарга, Азийн шашны энх тайвны чуулгын дарга, Японы шинэ залуу шашны хамтын нийгэмлэгийн тусгай зөвлөх, Нивано энх тайвны сангийн ерөнхийлөгч зэрэг чухал албан тушаалуудыг хашиж байна. (2009 оны байдлаар)

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Олон улсын хэлтсийн даргын булан

Талархах сэтгэлийн илэрхийлэл

Энэ сарын ерөнхийлөгчийн айлдварт Зургаан барамидын хоёр дахь барамид “Шагшаабад”-ын талаар сургасан байна. “Шагшаабад” нь “Зөв зуршлыг өөртөө хэвшүүлэх” гэсэн утгатай Sila хэмээх үгнээс гаралтай ба бодьсадвагийн үйл учраас гэгээлэг утга санааг агуулдаг. Шагшаабадыг “сахил” ч гэж хэлдэг тул өнөөг хүртэл “хийж болохгүй зүйл” гэсэн барьж хориглосон үйлээр төсөөлдөг байсан. Энэ сарын сургаалаар дамжуулан энэ ойлголтоо засан залруулж чадсан гэж бодож байна.

Бурхан, бодьсадвагийн үзэл санааны дагуу биднийг амьдруулж буй бүхий л зүйлсийн ач буянд талархаж, орчин тойрондоо амар амгаланг бий болгох нь хорвоогийн жам ёсыг дагаж буй хэрэг бөгөөд гэр бүлийнхэн, найз нөхөд, танил хүмүүстэйгээ эв найртай сайхан амьдрах зуршлыг өөртөө бий болгон хэрэгжүүлэх нь “шагшаабад” гэсэн бодьсадвагийн үйл хэмээн сургажээ. Ингээд бодоод үзэхээр энэ үйлийг өөдрөгөөр хүлээн авч хэрэгжүүлж болохоор байна.

Мөн энэхүү айлдвар өөртөө ямар зөв зуршлыг хэвшүүлэх шаардлагатай болох талаараа тунгаан бодох сайхан боломжийг олголоо. Урт, ширүүн өвлийн дараах хаврын сэвшээ салхи мэт тааламжтай, эв найртай хүмүүний харилцааг бий болгохыг уриалсан нь яг л энэ сард таарах зорилго гэж бодож байна.


Харин таны хувьд ямар шагшаабадын үйлийг хэрэгжүүлж гэж бодож байна вэ?

Кэйичи Акагава



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com
 URL: <https://sf-buddhism.org/>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rky39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: info@rkina.org
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

Korean Rissho Kosei-kai of Busan
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan
台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dharma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dharma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

Rissho Kosei-kai Ramu

Rissho Kosei-kai Aburkhill

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of the UK

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>